

ТУЗ-ийн 2023 оны 09-р сарын 12-ны өдрийн
23/001 тоот тогтоолын хавсралт

“МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ” ХХК



FINANCE

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

2023 он

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү бодлого нь МЭЙН СТРИТ ФИНАНС ББСБ /цаашид байгууллага гэх/-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар хүлээж болзошгүй алдагдлыг бууруулах, хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

ХОЁР. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ

- 2.1 Байгууллагад учирч болзошгүй эрсдэлийг доорх байдлаар ангилна.
- 2.2 Байгууллагын эрсдэл. Үүнд:
- 2.2.1 Үйл ажиллагааны эрсдэл: Байгууллагын дотоод процесс болон системийн үйл ажиллагаа доголдож байгууллага стратеги зорилгодоо хүрч чавахгүйд хүрэх, бизнесийн шийдлийн хэрэгжилт муу, өөрчлөгдөж буй нөхцөлд дасан зохицох зэргээс үүдэн бизнесийн боломжоо алдах эрсдэлийг хэлнэ.
 - 2.2.2 Зээлийн эрсдэл: Зээлдэгч нь гэрээний нөхцлийг дагаж мөрдөөгүйгээс үүдсэн алдагдлын эрсдэл юм.
 - 2.2.3 Санхүүгийн эрсдэл: Байгууллага үндсэн үйл ажиллагааны орлогоороо зардлаа санхүүжүүлж чадахгүй болох процессыг санхүүгийн эрсдэл гэнэ.
 - 2.2.4 Валютын ханшийн эрсдэл: Ханшийн хэлбэлзлээс үүссэн эрсдэлийг хэлнэ.
 - 2.2.5 Гадаад орчны эрсдэл: Бизнесийн үйл ажиллагааны хувьд нөлөөлөх гадаад орчны нөхцөл байдал, МУ-ын хууль эрх зүйн орчин, Зохицуулагч байгууллагаас батлагдсан дүрэм журмын хэрэгжилтийг хангаж биелүүлж чадахгүйн улмаас хүлээж болзошгүй алдагдал юм.
 - 2.2.6 Хуний нөөцийн эрсдэл: Шаардлагатай албан тушаал, орон тоонд шаардлага хангахгүй боловсон хүчнийг ажиллуулах эсвэл орон тооны дутагдалд орох.
 - 2.2.7 Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл: Байгууллагын нууцын зэрэглэлтэй мэдээлэл алдагдах, өөрчлөх, мэдээллийн системд зөвшөөрөлгүй хандан системийн үйл ажиллагааг тасалдуулахыг хэлнэ.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1 ТУЗ нь байгууллагын үйл ажиллагааны бүхий л чиглэлийг эрсдэлийн удирдлагаар хангаж, нэгдсэн үйл ажиллагааг хариуцан, дотооддоо мөрдөх зааврыг байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн батална.
- 3.2 Заавраар байгууллагын зорилго, зорилтод нөлөөлөх эрсдэл, ирээдүйд тохиолдох магадлал ба нөлөөллийг үнэлснээр эрсдэлд хариу өгөх арга хэмжээ, түүнийг үнэлэх үйл явцад мониторинг хийх зэрэг эрсдэлийн удирдлагын хүрээг тодорхойлно.
- 3.3 ТУЗ нь зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо, байхгүй бол Аудитын хороо нь байгууллагын эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэд хяналт тавина.
- 3.4 Энэхүү баримт бичгийг цаг үедээ тохируулан тухай бүр шинэчлэн батална.

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

- 4.1 Эрсдэлийг тодорхойлох: тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэх болон бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, гуравдагч талын харилцаа, зах зээлээс хамаарсан, эсхүл зохицуулалтын орчинд

гарсан өөрчлөлт зэргээс үүсэх магадлалтай эрсдэлийг байгууллагын бүхий л түвшинд тодорхойлно. Ингэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана:

- 4.1.1 Эрсдэлийн шинж чанар /nature of the risk/ - хаана, хэзээ, ямар үйл явдал;
 - 4.1.2 Эрсдэлийн эх үүсвэр /source of the risk/ - ямар хүчин зүйлс, хүн, үйл ажиллагаа;
 - 4.1.3 Эрсдэлийн шалтгаан /cause of the risk/ - шууд болон шууд бус шалтгаан;
 - 4.1.4 Эрсдэлийн нөлөө /effect of the risk/ - үүсэх үр дагавар, хамгийн сөрөг нөлөө.
- 4.2 Эрсдэлийг үнэлэх: эрсдэлийн нөлөөллийн хүчин зүйлсийг ялгаж харах зорилгоор ач холбогдлын түвшингээр нь ангилж, үнэлэх ба эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй арга зөв эсэхийг тогтмол шалгана. Эрсдэлийг чанарын болон тоон хэрэгслүүдийг ашиглан үнэлнэ.
- 4.3 Эрсдэлийг удирдах: эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлд үзүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох ба эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 4.4 Гүйцэтгэх удирдлага нь эрсдэлийн удирдлагын зааврын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулж, байгууллагын эрсдэлийг тодорхойлон үнэлж, удирдах үйл ажиллагааг явуулна.
- 4.5 Гүйцэтгэх удирдлагын дэргэд байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын нэгж, эсхүл ажилтан байх бөгөөд бусад гүйцэтгэх шатны удирдлагуудтай байнгын харилцан холбоотой ажиллана.
- 4.6 Гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын нэгж эсхүл ажилтнаар дамжуулан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө тухайн байгууллагад нийцсэн үр дүнтэй эсэх, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавин ажиллана.

ТАВ. АЖЛЫН ТАЙЛАН

- 5.1 Эрсдэлийн хороо нь хагас болон бүтэн жилээр эрсдэлийн үнэлгээг дүгнэж ТУЗ-д танилцуулна.